



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/171/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024      Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:              Б.Азбаяр

Утас: 99061429      Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/94  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ Г

Г ГАЛУУТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ С.ЦЭГМИД ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519174

E:\ajil\2019 on\STA 2018\11. Galuut EBS\4.Tailagnal\Аудитын гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

---

### **2.1. Оршил**

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Цэгмидэд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.03-ны өдрийн № 01 албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Ард иргэдэд урлаг соёлын үйлчилгээг чанартай хүргэж, чадварлаг боловсон хүчинтэй тогтмолжсон үйл ажиллагаатай болж чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажилчдын ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл:

Бага дунд боловсролын тухай хуулийн тухай хуулиар Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous” программ хангамж ашигладаг байна.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон ба аккрузал сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзлээ.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны Нийт зардал 1051920.4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 21038,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	2.3	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2.3</b>	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.8.1.1. Эд хариуцагч тайлангийн орлогыг 1617.6 мянга, зарлагыг 1813.8 мянган төгрөгөөр мянган төгрөгөөр дутуу гарагсан тул баримтыг бүрдүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2.8.1.2. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 349.1 мянга, шатахууны зардлаас 60.3 мянга, ном хэвлэлийн зардлаас 92.5 мянган төгрөг зарцуулахдаа анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 710724,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 710385,2 мянган төгрөг буюу 99,9 хувьтай бөгөөд оны эцэст 379.0 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээнээс хугацаадаа 22 мэдээ, хугацаа хоцорсон 2, мэдээлээгүй 1 мэдээ, 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 1160.7 сая төгрөгийн 35 гүйлгээнээс 1097.9 мянган төгрөгийн 31 гүйлгээг мэдээлж, 62.8 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байсан тул Шилэн дансны хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>37,161,953.94</u></b>	<b><u>56,492,329.94</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	539,133.00	575,630.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	539,133.00	575,630.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,622,820.94	55,916,699.94
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	194,300.00	00.00
35130	Эм боох материал	194,300.00	00.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,428,520.94	55,916,699.94
35410	Бичиг хэргийн материал	811,000.00	959,420.00
35420	Аж ахуйн материал	33,453,805.94	54,194,329.94
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	379,000.00	245,000.00
35460	Хүнсний материал	784,715.00	517,950.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,596,421,006.01</u></b>	<b><u>1,538,351,388.98</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,596,421,006.01	1,538,351,388.98
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,596,275,000.29	1,500,227,643.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,565,872,206.00	1,367,163,240.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-431,774,835.36	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,252,073.27	150,629,073.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,701,693.50	-97,804,511.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,118,985.22	144,568,985.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,286,553.26	-75,473,602.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	361,751,200.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-36,277,640.28	00.00
39217	Ном	10,321,258.20	11,144,458.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	146,005.72	38,123,745.72
39301	Програм хангамж	352,600.00	352,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-206,594.28	-228,854.28
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	38,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,633,582,959.95</u></b>	<b><u>1,594,843,718.92</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>464,522.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	464,522.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	464,522.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	464,522.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,633,582,959.95</u></b>	<b><u>1,594,379,196.92</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,633,582,959.95	1,594,379,196.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,270,640,649.12	1,308,640,649.12
51101	Өмч: - төрийн	1,270,640,649.12	1,308,640,649.12
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	27,599,579.83	-251,615,623.09
51210	Өмнөх үеийн үр дүн	27,599,579.83	27,599,579.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-279,215,202.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	335,342,731.00	537,354,170.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,633,582,959.95</u></b>	<b><u>1,594,843,718.92</u></b>

### Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>491,167,534.00</b>	<b>772,705,171.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>200,000.00</b>	<b>52,255,280.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	200,000.00	52,255,280.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	52,255,280.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	540,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	51,715,280.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>9,195,534.00</b>	<b>10,225,691.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	481,772,000.00	710,224,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	3,119,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,119,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	9,195,534.00	7,106,691.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,195,534.00	7,106,691.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>505,141,732.02</b>	<b>780,992,643.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>505,141,732.02</b>	<b>780,992,643.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	441,756,091.02	736,157,915.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	307,906,757.00	432,201,011.00
210101	Үндсэн цалин	293,173,385.00	397,891,068.00
210104	Урамшуулал	14,733,372.00	34,309,943.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,843,017.00	51,696,760.00
210201	Тэтгэврийн даатгал	33,843,017.00	51,696,760.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,835,846.00	133,898,551.00
210301	Гэрэл, цахилгаан	8,054,666.00	4,392,551.00
210302	Түлш, халаалт	11,511,180.00	128,690,400.00
210303	Цэвэр, бохир ус	270,000.00	815,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,418,950.00	5,362,445.00
210401	Бичиг хэрэг	933,060.00	565,480.00
210402	Тээвэр, шатахуун	2,195,350.00	3,148,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,099,740.00	399,445.00
210404	Ном, хэвлэл	32,000.00	92,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,775,300.00	1,007,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	383,500.00	148,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	22,708,592.00	38,786,559.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	97,200.00	376,500.00
210502	Хоол, хүнс	22,611,392.00	38,368,059.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	42,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,056,050.00	5,683,000.00
210604	Урсгал засвар	3,056,050.00	5,683,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	408,600.00	286,000.00
210702	Дотоод албан томилолт	408,600.00	286,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	612,000.00	400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	612,000.00	400,000.00

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,966,279.02	67,843,589.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	645,000.00	1,163,463.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,000.00	4,154,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,289,279.02	62,525,526.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	63,385,641.00	44,834,728.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	63,385,641.00	44,455,680.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,195,534.00	7,106,691.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,280,907.00	17,661,589.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,426,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,182,400.00	19,487,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	379,048.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	379,048.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-13,974,198.02</b>	<b>-8,287,472.83</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	270,927,730.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	242,161,170.29
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	28,766,559.80
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-270,927,730.09
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-13,974,198.02</b>	<b>-279,215,202.92</b>

**Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>677,981,750.00</b>	<b>720,989,891.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>695,000.00</b>	<b>540,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	695,000.00	540,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	695,000.00	540,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	695,000.00	540,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>677,286,750.00</b>	<b>720,449,891.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	665,785,500.00	710,224,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	3,119,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,119,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	11,501,250.00	7,106,691.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	11,501,250.00	7,106,691.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>677,981,750.00</b>	<b>720,989,891.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>677,981,750.00</b>	<b>720,989,891.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>582,264,335.00</b>	<b>673,136,819.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	421,404,687.00	431,114,409.00
210101	Үндсэн цалин	326,526,021.00	346,848,853.00
210102	Нэмэгдэл	55,120,700.00	55,812,900.00
210104	Урамшуулал	28,427,171.00	28,452,656.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,330,795.00	00.00

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,251,020.00	52,405,337.00
210201	Тэтгэврийн даатгал	47,251,020.00	35,132,713.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	4,317,944.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	3,454,550.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,020,059.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	8,480,071.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	45,514,306.00	133,391,371.00
210301	Гэрэл, цахилгаан	9,490,526.00	4,645,051.00
210302	Түлш, халаалт	35,486,780.00	127,690,400.00
210303	Цэвэр, бохир ус	537,000.00	1,055,920.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,965,449.00	5,188,445.00
210401	Бичиг хэрэг	801,910.00	663,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,208,994.00	2,908,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,554,645.00	399,445.00
210404	Ном, хэвлэл	954,900.00	465,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,445,000.00	751,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	41,736,850.00	35,727,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	291,500.00	182,200.00
210502	Хоол, хүнс	31,957,950.00	35,082,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,487,400.00	462,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,827,450.00	6,739,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,200,000.00	00.00
210602	Тавилга	00.00	3,900,000.00
210604	Урсгал засвар	5,627,450.00	2,839,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	578,100.00	286,000.00
210702	Дотоод албан томилолт	578,100.00	286,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,110,293.00	284,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,110,293.00	284,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,876,180.00	8,000,457.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,476,180.00	2,308,757.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	5,691,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>95,717,415.00</b>	<b>47,853,072.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	95,311,243.00	47,474,024.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	11,501,250.00	7,106,691.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,517,359.00	20,679,933.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,426,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,182,400.00	19,487,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,683,434.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	406,172.00	379,048.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	406,172.00	379,048.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

### Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,270,640,649.12</b>	<b>335,342,731.00</b>	<b>27,599,579.83</b>	<b>00.00</b>	1,633,582,959.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,270,640,649.12</b>	<b>335,342,731.00</b>	<b>27,599,579.83</b>	<b>00.00</b>	1,633,582,959.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	202,011,439.89	00.00	00.00	202,011,439.89
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	38,000,000.00	00.00	-279,215,202.92	00.00	-241,215,202.92
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,308,640,649.12</b>	<b>537,354,170.89</b>	<b>-251,615,623.09</b>	<b>00.00</b>	1,594,379,196.92

### Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	608,343,000.00	595,032,715.00	710,724,200.00	710,385,152.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	608,343,000.00	595,032,715.00	710,724,200.00	710,385,152.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	576,701,200.00	563,400,745.00	670,353,500.00	670,017,819.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	434,909,000.00	423,123,950.00	429,882,700.00	430,114,409.00
210101	Үндсэн цалин	333,724,700.00	329,855,925.00	345,616,500.00	345,848,853.00
210102	Нэмэгдэл	44,365,200.00	44,712,675.00	55,812,900.00	55,812,900.00
210104	Урамшуулал	36,990,300.00	30,016,250.00	28,453,300.00	28,452,656.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,828,800.00	18,539,100.00	00.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,033,900.00	46,532,569.00	52,251,400.00	51,706,337.00
210201	Тэтгэврийн даатгал	48,033,900.00	46,532,569.00	34,945,700.00	34,433,713.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	4,351,000.00	4,317,944.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	3,454,600.00	3,454,550.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	863,700.00	1,020,059.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	8,636,400.00	8,480,071.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,223,000.00	42,222,905.00	133,392,900.00	133,391,371.00
210301	Гэрэл, цахилгаан	4,645,100.00	4,645,100.00	4,645,100.00	4,645,051.00
210302	Түлш, халаалт	36,107,900.00	36,107,805.00	127,691,800.00	127,690,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,470,000.00	1,470,000.00	1,056,000.00	1,055,920.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,533,100.00	6,522,775.00	5,188,500.00	5,188,445.00
210401	Бичиг хэрэг	1,376,400.00	1,366,400.00	663,900.00	663,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,344,900.00	2,344,900.00	2,908,200.00	2,908,200.00

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,414,800.00	1,414,475.00	399,500.00	399,445.00
210404	Ном, хэвлэл	273,200.00	273,200.00	465,500.00	465,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,123,800.00	1,123,800.00	751,400.00	751,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,658,800.00</b>	<b>31,658,590.00</b>	<b>35,748,200.00</b>	<b>35,727,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	279,000.00	278,900.00	182,200.00	182,200.00
210502	Хоол, хүнс	30,918,100.00	30,917,990.00	35,103,600.00	35,082,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	461,700.00	461,700.00	462,400.00	462,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,371,700.00</b>	<b>1,371,700.00</b>	<b>5,319,000.00</b>	<b>5,319,000.00</b>
210602	Тавилга	00.00	00.00	3,900,000.00	3,900,000.00
210604	Урсгал засвар	1,371,700.00	1,371,700.00	1,419,000.00	1,419,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>560,500.00</b>	<b>557,600.00</b>	<b>286,000.00</b>	<b>286,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	560,500.00	557,600.00	286,000.00	286,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>538,000.00</b>	<b>537,600.00</b>	<b>284,300.00</b>	<b>284,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	538,000.00	537,600.00	284,300.00	284,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10873200.00</b>	<b>10873056.00</b>	<b>8000500.00</b>	<b>8000457.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,873,200.00	10,873,056.00	2,223,200.00	2,308,757.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	5,777,300.00	5,691,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31641800.00</b>	<b>31631970.00</b>	<b>40370700.00</b>	<b>40367333.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,641,800.00</b>	<b>31,631,970.00</b>	<b>40,370,700.00</b>	<b>40,367,333.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,795,000.00	18,785,170.00	20,680,000.00	20,679,933.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,846,800.00	12,846,800.00	19,487,400.00	19,487,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	203,300.00	200,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>608,043,000.00</b>	<b>595,032,284.00</b>	<b>710,724,200.00</b>	<b>710,385,152.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>608,043,000.00</b>	<b>595,032,284.00</b>	<b>710,224,200.00</b>	<b>709,845,152.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	608,043,000.00	595,032,284.00	710,224,200.00	709,845,152.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>500,000.00</b>	<b>540,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	500,000.00	540,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>52.00</b>	<b>52.00</b>	<b>52.00</b>	<b>52.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	34.00	34.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00	17.00	17.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>400.00</b>	<b>428.00</b>	<b>414.00</b>	<b>454.00</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>400.00</b>	<b>428.00</b>	<b>414.00</b>	<b>454.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	400.00	428.00	414.00	454.00